

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2023 ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ

УЛААНБААТАР ХОТ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар
2. Хурлаар хэлэлцэх асуудал
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
4. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
5. Компанийн нийгмийн хариуцлагын тайлан
6. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан
7. Компанийн засаглалын бүтэц, үйл ажиллагаа
 - Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
 - Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд тэдгээрийн эзэмшилд буй хувьцааны талаарх мэдээлэл
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан
8. Хөрөнгийн зах зээл ба компанийн хувьцааны үнэ ханш
9. Компанийн ногдол ашиг хуваарилалт
10. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд Төлөөлөн удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
11. Компанийн 2024 оны үйл ажиллагааны зорилтыг танилцуулах
12. Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай
13. Хурлаас гарах тогтоолын төсөл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Гермес центр” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 2-р сарын 14-ний өдрийн №5 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн 15:00 цагт тус компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд зохион байгуулахаар болсон тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2024 оны 03-р сарын 07-ны өдрөөр тасалбар болгоно.**

Хурлаар хэлэлцэх асуудал :

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, дилерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, “Гермес центр”ХК-ийн төв оффисын байрны 3 давхар № 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах:

Комиссын дарга : О.Энхтуяа, утас 9909-4991, имэйл хаяг: enkhee_7777@yahoo.com
Гишүүн : Д.Эрдэнэсүрэн, утас 9908-8571, имэйл хаяг: erdenesuren2213@gmail.com

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн тухай
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
3. Компанийн 2024 оны зорилтын тухай
4. Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хэлэлцүүлэгч	Хурлын шийдвэр
1	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах	5 минут	Хурал зохион байгуулах комисс	Хурлын тэмдэглэлд оруулах
2	Хурлын тэргүүлэгчийг сонгосон тухай	5 минут	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Хурлын тэмдэглэлд оруулах
3	Хурлын тооллогын комиссын дүнг танилцуулах	5 минут	Тооллогын комисс	Тогтоолоор батлах
4	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан	10 минут	Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
5	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт	10 минут	Аудитын хорооны дарга Д.Туяа	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
6	Компанийн 2024 оны үйл ажиллагааны зорилт		Гүйцэтгэх захирал Б.Оюунцэцэг	Хурлын тэмдэглэлд оруулах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	
7	Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай		ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн	Тогтоолоор батлах
	Санал шүүмжлэл	5 минут	Хувьцаа эзэмшигчид	

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Гермес Центр” ХК нь өнгөрсөн 2023 онд 16 ажилтан ажиллагсадтайгаар, батлагдсан орлого, зарлагын төсөв, төлөвлөгөөний дагуу барилгын материалын “Гермес” худалдааны төвийн үйл ажиллагааг хэвийн явууллаа.

Гүйцэтгэх удирдлагын баг нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хүний нөөцийн талаар:

- Компанийн ажилтан ажиллагсадтай 2023 оны гэрээг шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аас улирал тутамд дүгнэж байна.
- Ажиллагсдын ээлжийн амралтын хуваарийг баталж, улмаар хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлж байна. Мөн сар бүр ажилтан ажиллагсдын ажил, амралтын хуваарийг баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
- Компанийн нягтлан бодогч, мэргэжилтэн нар нь өөрсдийн хариуцсан ажилтан ажиллагсдад өдөр бүр ажил хэргийн мэдээ, мэдээллийг өгч, харилцан зөвшилцөх зарчмаар хамтран ажиллаж байна. Мөн гүйцэтгэх захирал сар бүр ажиллагсдын хурлыг тогтмол хийж, шаардлагатай мэдээллийг өгч байна.
- Худалдааны төвийн түрээслэгч “Евро ази сервис” ХХК-тай хамтран компанийн ажилтан ажиллагсдыг Нийслэлийн онцгой байдлын сургалтын төвд “Гамшгаас хамгаалах бэлэн байдал”-ын сургалтанд хамрууллаа. Ингэснээр гал түймэр, газар хөдлөлтийн талаарх анхан шатны мэдлэгтэй болж, улмаар гамшгийн үед хэрэгжүүлэн ажиллах анхан шатны аргачлалд суралцсан.
- Батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу хуваарьт ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.

2. Түрээслэгчдийн талаар:

- Гүйцэтгэх удирдлагын баг нь 2023 онд нийт 213 түрээслэгчидтэй түрээсийн гэрээ байгуулсан бөгөөд тэдгээрийн бараа материалыг даатгалд бүрэн хамруулсан. Түрээсийн талбай 100 хувь түрээслэгдсэн.
- Худалдааны төвийн түрээслэгчидтэй байгуулсан 2023 оны түрээсийн гэрээний гүйцэтгэлийн явцын үнэлгээг түрээслэгч тус бүртэй хамтран дүгнэж, улмаар 2024 оны 1, 2-р сарын түрээсийн төлбөрт
 - ✓ 91-ээс дээш оноо авсан нийт 135 түрээслэгчдэд 10%-ийн хөнгөлөлт
 - ✓ 71-90 хүртэлх оноо авсан нийт 77 түрээслэгчдэд 5%-ийн хөнгөлөлт үзүүллээ.
 - ✓ 61-70 хүртэлх оноо авсан нийт 1 түрээслэгчдэд хөнгөлөлт үзүүлээгүй болно.
- Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Мөн түрээслэгчдээс ирсэн санал, хүсэлт, гомдлыг тухай бүр харилцан зөвшилцөх зарчмаар шийдвэрлэн хамтран ажиллаж байна.
- Худалдааны төвийн авто зогсоолын хүрэлцээг худалдан авагч, үйлчлүүлэгчдэд хүрэлцээтэй байлгах зорилгоор түрээслэгч тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудын авто машиныг нэвтрүүлэхгүй байхаар шийдвэрлэж, холбогдох арга

хэмжээг авч ажиллаж байна. Ингэснээр зорилтот хэрэглэгчдэд автозогсоолын хүртээмжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж чадсан.

3. Галын аюулгүй байдлын талаар:

- БГД-ийн Онцгой байдлын хэлтсээс 2023 оны галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг гаргуулан авсан.
- Худалдааны төвд ашиглагдаж байгаа галын хорны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, ашиглалтын хугацаа дууссан болон эвдэрч гэмтсэн галын хорнуудыг шинэчлэн солилоо. Мөн ашиглалтын явцад эвдэрч гэмтсэн аваарийн гэрэл, гарц заасан тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн солив.
- Худалдааны төвийн лангуу, павильон түрээслэгчдийн ашиглаж байгаа галын хорны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, ашиглалтын хугацаа дууссан болон эвдэрч муудсан галын хорнуудыг шинэчлэн солиуллаа.
- Худалдааны төвийн тамхи татдаг түрээслэгч, худалдагч, туслах ажилтнууд болон худалдан авагчдыг худалдааны төвийн баруун болон зүүн талд байрлах зориулалтын тамхины цэгт тамхиа татах, асаасан шүдэнзийг сайтар унтраах талаар анхааруулгыг тогтмол өгч, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.
- Худалдааны төвийн түрээслэгч, тэдгээрийн худалдагч, туслах ажилтнуудад галын аюултай нөхцөл байдлаас хэрхэн урьдчилан сэргийлж ажиллах талаарх зөвлөгөө, мэдээллийг сар бүрийн захидлаар дамжуулан хүргүүлж байна.

4. Харуул хамгаалалтын талаар:

- Худалдааны төвийн зохицуулагч нарт хулгай, залилан, дээрэм тонуулаас урьдчилан сэргийлж ажиллах талаар зөвлөгөөг тогтмол өгч байна.
- Худалдааны төвийн гадна, дотор талын хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хангаж, тусгайлсан дэвтэрт тэмдэглэгээ хийж, эвдэрч гэмтсэн тохиолдолд тухай бүр засварлаж байна.
- Худалдааны төвийн хашаанд гадны автомашин хонуулахгүй байна. Худалдааны төв дотор зөвшөөрөлгүй гар дээрээс худалдаа, наймаа эрхэлж байгаа иргэд болон автомашинтай иргэдэд шаардлага тавин ажиллаж байна.
- Худалдааны төв нь Нийслэлийн болон БГД-ийн 25-р хорооны хэсгийн цагдаатай хамтран халаасны хулгай, цахим гэмт хэрэг, залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, сурталчилгааны ажлыг түрээслэгчдийн дунд явууллаа.

5. Аж ахуйн засварын талаар:

- Худалдааны төвийн А, Б корпуст жижиг засварын ажлуудыг өдөр бүр тогтмол хүргүүлж байна.
- Худалдааны төвийн эргэн тойрон дахь хүлээлгийн сандал, аваарын шат, шатны бариул, шатны ирмэг, хогийн сав, тамхины цэг зэргийг будаж, хагарч гэмтсэн тохиолдол бүрт засварлаж байна.
- Худалдааны төвийн авто машины зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, хашлага зэргийг будаж, хагарч бутарсан хашлагыг тухай бүр сольж байна.
- Худалдааны төвийн хашааны зэвэрч муудсан төмөрнүүдийг сольж, суурийн хэсэгт замаска хийж, будсан. Мөн хашааны гүйдэг хаалганы босоо төмөр, дугуй зэргийг сольж, хашааны харагдах байдал, өнгө үзэмж, түүнчлэн оройн цагаар гадны хүн нэвтрэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч байна.
- Худалдааны төвийг цахилгаанаар хангадаг цахилгааны 10 000 квт-ын хос шугамд 3 гэмтэл гарсныг “УБЦТС” ТӨХК-ийн Кабель засварын төвөөр засварлуулж, бэлэн

байдлыг хангалаа. Мөн цахилгааны нөөц эх үүсвэр болох дизель станцыг засварлуулж, худалдааны төвийг хэвийн ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

- Зуны улиралд бороо их орсонтой холбоотойгоор Б корпусын дээврээс ус их хэмжээгээр гоожсон тул дээврийн ус зайлуулах хоолойг мэргэжлийн байгууллагаар засварлууллаа. Түүнчлэн Б блокийн суулт өгсөн суурийн хэсгийг зориулалтын бодисоор шавардаж, явган замын хавтанг дахин суурилуулав. Мөн Б корпусын цонхны хаалганд тоосгон өрлөг хийж өндөрлөн, улмаар витум түрхэж, дахин ус нэвчихээс сэргийлж ажиллав. Ингэснээр түрээслэгчдийн бараа материалыг норж гэмтэхээс сэргийлж ажиллалаа.
- Гэнэтийн их борооны улмаас Б корпусын С давхарт үерийн ус нэвтэрч орсныг шуурхай арга хэмжээ авч ажиллав. Мөн тухайн нөхцөл байдлыг даатгалын компаниудын шуурхай группт илтгэж баримтжуулснаар хохирлыг барагдуулан нөхөн төлбөрийг авч чадлаа.
- Худалдааны төвийн цэвэр, бохир усны тоолуурын баталгаат хугацаа дууссаныг шинэчлэн баталгаажууллаа.

6. Цэвэрлэгээ, үйлчилгээний талаар:

- Худалдааны төвийн гадна болон дотор талд өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, түрээслэгч, худалдан авагчдад цэвэр цэмцгэр, ая тухтай орчныг бүрдүүлэн ажиллаж байна.
- Худалдааны төвийн захиргаа сар бүрийн эхний долоо хоногийн баасан гаригийг их цэвэрлэгээний өдөр болгон зарласан. Ингэснээр лангуу, павильон түрээслэгчид нь өөрсдийн лангуу павильондоо их цэвэрлэгээ хийж, улмаар зарж борлуулж буй бараа материалаа эмх цэгцтэй хураан байршуулах зэргээр худалдан авагчдад ая тухтай, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэн ажиллаж байна.
- Худалдааны төвийн хог хаягдлыг 7 хоног бүр ачуулж, улмаар гадна талбайд байрлах хогийн функерийг ариутган цэвэрлэж байна.
- “Хог хаягдлын тухай хууль”-ийн 10.2.10 дахь заалтын дагуу худалдааны төвийн эргэн тойрон дахь нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас мөсийг тухай бүр цэвэрлэж байна.
- Худалдааны төвийн А, Б блокт хулганы хор цацуулж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна.

7. Архив бичиг хэргийн талаар:

- Өмнөх оны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой баримтууд, түрээсийн гэрээ, ТУЗ, ХЭХуралтай холбоотой баримт материалуудыг үдэж, архивласан.
- Түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу түрээсийн тодорхойлолт, түрээс төлөлтийн тайлан зэрэг мэдээ мэдээллийг гарган өгч байна.
- СЗХ, МХБирж болон бусад харилцагч байгууллагуудаас ирүүлсэн албан тоотуудыг бүртгэлжүүлж, холбогдох хариуг боловсруулан хүргүүлж байна.

8. Олон нийттэй харилцах талаар:

- Компанийн www.hermescenter.mn, МХБ-ийн www.mse.mn цахим хуудсан дахь ТУЗ, ХЭХ болон компанийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж байна.
- Худалдааны төвийн түрээслэгчдэд сар бүрийн захидлаар дамжуулан тухайн сард хийгдсэн ажил үйлчилгээ, дараагийн сарын ажил амралтын өдөр, ажиллах цагийн

хуваарь, худалдааны төвийн дотоод журам зэргийн талаарх мэдээ мэдээллийг тогтмол хүргүүлж байна.

- Худалдааны төвийн давхарт бүрт байрлах мэдээллийн самбарны мэдээллүүдийг сар бүр шинэчилж байна.

9. Санхүүгийн талаар:

- Компанийн мөнгөн урсгалын тооцоог урьдчилан гаргаж, мөнгөн хөрөнгийн зохицуулалтыг тогтмол хийж байна.
- Компанийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.
- Санхүүгийн тайлан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох зохицуулагч байгууллагуудад тайлагнаж байна.
- Улсад төлөх ёстой татвар хураамж, ашиглалтын болон бусад зардлуудыг цаг тухайд нь бүрэн төлж байна.
- Худалдааны төвийн түрээслэгчдээс авах түрээсийн орлогыг тухайн сардаа багтааж бүрэн хураан авч, түрээсийн төлбөрийн үлдэгдэлгүй ажиллаж байна.
- Ажиллагсдын ээлжийн амралтын нөхөн олговор, ХЧГА-ны тэтгэмж зэргийг цаг тухайд нь холбогдох хууль, журмын хүрээнд тооцон олгож байна.
- Гүйцэтгэх захирлын цалин урамшуулалд 99.2 сая төгрөгийг олгосон.
- Хөндлөнгийн аудитын “Си Эс Ай” ХХК-тай гэрээ байгуулж, компанийн санхүүгийн тайланд жилд 2 удаагийн хяналт шалгалтыг хийлгэж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

1. Нийслэл болон БГДүүргээс зохион байгуулж байгаа олон нийтийг хамарсан цэвэрлэгээ үйлчилгээнд ажиллагсадаа тогтмол оролцуулж, худалдааны төвийн ойр орчмын 50м хүртэлх нийтийн эдэлбэр газрыг байнга цэвэрлэж, оршин байгаа дүүрэг хорооныхоо өнгө үзэмжинд өөрсдийн хувь нэмрээ оруулж байна.
2. “Непко кидс” ХХК-тай хамтран дэлхийн номын өдөрлөгийг хамтран зохион байгуулж ажиллалаа.
3. “Монос” групп-тэй хамтран “Дархлаа дэмжье” аяныг иргэдийнхээ дунд зохион байгууллаа. Аяны хүрээнд ясны сийрэгжилт, цусны даралт, хүчилтөрөгчийн дутагдал, арьсны оношилгоо хийх зэргээр эмнэлэг, гоо сайхны анхан шатны үзлэг оношилгоог хийж, улмаар түрээслэгч иргэдэд мэргэжлийн эмч зөвлөгөөг өгч ажиллав.
4. “Худалдаа хөгжлийн банк”-тай хамтран Бритто карт, Хуримтлалтай Монгол хадгаламжийн тухай өдөрлөгийг түрээслэгчдийн дунд зохион байгууллаа. Мөн “Капитрон банк”-тай хамтран гадаад гуйвуулгын картыг хэрхэн ашиглах талаарх мэдээ мэдээллийг өглөө.
5. “Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсрол төв”-тэй хамтран Иргэн бүрт эрүүл мэнд сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтын зорилго нь иргэдийн дундаж наслалтыг дээшлүүлэх, эрүүл амьдарлын хэв маягийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд сургалтаар хоол зүй, сэтгэл зүй, нойр, дасгал хөдөлгөөн биеийн дархлаа, эрдэс бодисын зөв зохистой хэрэглээний талаарх мэдээллийг түрээслэгч, худалдагч, туслах ажилтнуудад өглөө.
6. “Монгол даатгал” ХХК-тай хамтран даатгал гэж юу болох, даатгалын ач холбогдол, даатгалын төрөл зүйл, даатгалын хамрах хүрээ болон даатгуулагчид учирсан аливаа хохирлыг хэрхэн барагдуулах талаарх анхан шатны мэдээ мэдээллийг танилцууллаа.
7. Худалдааны төвийн түрээслэгчид, тэдгээрийн худалдагч ажилтнуудад болон иргэдэд зориулан хэрэглээний усны зөв зохистой ашиглалтын талаарх таниулга сурталчилгааг тогтмол хийж байна.
8. Баянгол дүүргийн Цахилгаан түгээх сүлжээ төвтэй хамтран “Тогоо тохируулья” нийгмийн нөлөөллийн аянд нэгдэж, улмаар худалдааны төвийн түрээслэгчдэд цахилгаан эрчим хүчний оргил ачааллын үе болох 17:00 – 22:00 цагийн хооронд эрчим хүчний хэрэглээгээ боломжит хэмжээгээр хэмнэж, зөв зохистой хэрэглэх талаарх таниулан сурталчлах ажлыг тогтмол хийж байна. Үүний үр дүнд эрчим хүчийг тодорхой хэмжээнд хэмнэж, Улаанбаатар хотынхоо эрчим хүчний системд дэмжлэг үзүүлэн, улс орныхоо өмнө хүлээсэн нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажиллалаа.
9. Худалдааны төвийн эргэн тойрон дахь ногоон байгууламжийг байнга тордож, иргэдээ эрүүл ая тухтай, цэвэр цэмцгэр орчинд таатай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлж байна
10. Манай худалдааны төвийн захиргаа нь хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх ажлыг цогцоор нь шийдвэрлэн ажиллаж ирсэн бөгөөд энэхүү ажлын хүрээнд түрээслэгчдийн бараа материалын сав баглаа боодол, ус ундааны хуванцар сав зэргийг ангилан ялгаж эдийн засгийн эргэлтэнд оруулж байна. Үүний үр дүнд 2023 онд 10 гаруй тонн цаасан хог хаягдал болон ус ундааны хуванцар сав, шил зэргийг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт тушаалаа.

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН


- Компанийн 2023 оны санхүүгийн үндсэн үзүүлэлтийн тухай :
 - Компанийн нийт хөрөнгө 8,955.4 сая төгрөг бөгөөд үүнээс:
 - ✓ Эргэлтийн хөрөнгө 3,059.6 сая төгрөг
 - ✓ Үндсэн хөрөнгө 3,607.3 сая төгрөг
 - ✓ Биет бус хөрөнгө 2,288.5 сая төгрөг
 - Эзэмшигчийн өмч хөрөнгө 8,594.7 сая төгрөг
 - Татварын дараах цэвэр ашиг 1,698.3 сая төгрөг байна.
- Орлогын үр дүнгийн тухай : Компани 2023 онд 2,556.5 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллалаа. Борлуулалтын орлогын төлөвлөгөө 2,537.3 сая төгрөг байсантай харьцуулахад 101%-ийн биелэлттэй гарсан. Орлогыг төсөвлөснөөс 19.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Хадгаламжийн хүүний орлогын төлөвлөгөө 270.0 сая төгрөг байсан бол гүйцэтгэл 296.0 сая төгрөг болж төлөвлөгөөг 26.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллалаа.
- Зардлын тухай : Компани 2023 онд 965.7 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлын төлөвлөгөө 1,061.2 сая төгрөгтэй харьцуулахад 91%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 95.5 сая төгрөгөөр хэмнэн ажиллалаа.
- Ашгийн тухай : Татварын дараах цэвэр ашиг 1,698.3 сая төгрөг гарсныг ашгийн төлөвлөгөө 1,571.6 сая төгрөг байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 126.7 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.
- Ногдол ашгийн тухай : 2023 онд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 21 төгрөг 62 мөнгө гарсан. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн төлөвлөгөө 20 төгрөг 01 мөнгөг байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 1 төгрөг 61 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан.

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Компанийн 2019 - 2023 он хүртэлх сүүлийн 5 жилийн эдийн засгийн ерөнхий судалгаа


График 1

Компанийн 2023 оны орлогын бүтэц



Компанийн орлого, зардал, ашиг

График 2




КОМПАНИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, ШИМТГЭЛ

Манай компани 2023 онд улсад нийт 704.1 сая төгрөгийн татварыг төлсөн байна. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 165.6 сая төгрөг
- НДШимтгэлд 92.7 сая төгрөг
- ХХОАТатварт 36.0 сая төгрөг
- НӨАТатварт 251.3 сая төгрөг
- ҮХЭХАТатварт 56.6 сая төгрөг
- Ногдол ашгийн татварт 90.1 сая төгрөг
- Газрын төлбөрт 11.8 сая төгрөг

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол улсын татварын албанд төлсөн татварын хэмжээ


График 3



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

“Гермес Центр” ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, компанийн нийт ажилтан ажиллагсад, түрээслэгч, үйлчлүүлэгч зэрэг талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилго, зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, чиглүүлэх, хянахад чиглэсэн бүтэц юм.

График 4



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Манай компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 7-ны өдөр Гермес Центр ХК-ийн оффисын 3-р давхрын хурлын танхимд хуралдсан. Хурлын ирц 86.61%-тай байсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Гермес Центр” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь 2022 оны батлагдсан төсөв төлөвлөгөөг биелүүлэн хангалттай сайн ажилласан гэсэн дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан.
2. Компанийн ТУЗ-ийн 2023 оны төсвийг хэлэлцэж, улмаар хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан.
3. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4-р сарын 07-ны өдрийн ээлжит хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг холбогдох материалуудын хамт СЗХороо, МХБиржид тус тус хүргүүлсэн.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Гермес Центр” ХК нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус баталсан дүрэм, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг.

1. Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлуудыг (2023.02.15, 2023.05.26, 2023.08.23, 2023.12.06) холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүдийг СЗХ болон МХБиржид хүргүүлсэн.
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлуудыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, хурлаас гаргасан санал, зөвлөмжийг ТУЗ-ийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд оруулж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан.
3. Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 2022 оны сүүлийн хагас жил, 2023 оны эхний хагас жилийн ногдол ашгийн мөнгийг компанийн төв байр болон “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд бүрэн байршуулан тараасан.
4. СЗХорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу компанийн 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг холбогдох маягтын дагуу бэлтгэж, СЗХ болох МХБ-д тус тус хүргүүлэн ажиллалаа. Мөн МХБ-ийн www.mse.mn цахим хуудас, өөрийн компанийн www.hermescenter.mn цахим хуудсанд тус тус нийтэлж олон нийтэд мэдээллээ.
5. СЗХорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг холбогдох маягтын дагуу өөрийн компанийн засаглалыг үнэлж дүгнэн СЗХ болон МХБ-д хүргүүлсэн. Үнэлгээгээр манай компани 98.6% хувь буюу эрсдэлгүй хэвийн засаглалтай гэсэн дүгнэлт гарсан.

6. Бүртгэлтэй брокер дилерийн компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн гадаад дотоодын хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч холбогдох мэдээ, мэдээллийг өгч байна.
7. Компанийн вэб сайт, мэдээллийн самбарны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж ирлээ.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Манай компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн дагуу өөрийн компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталж, улмаар холбогдох бодлогын баримт бичиг, заавар журмуудыг шинээр болон шинэчлэн баталж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

“Монголын Хөрөнгийн бирж”-ээс 2022 онд шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодексийг үнэлэх үнэлгээ”-ний аргачлалын дагуу 2023 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаарх “Гермес Центр” ХК-ийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн талаарх мэдээлэл.

”Гермес Центр” ХК-ийн засаглалын кодексийн нэгдсэн үнэлгээ

Хүснэгт 1

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83.3%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
Нэгдсэн дүн		72	71		98.6%

Дүгнэлт

“Гермес Центр” ХК нь 2023.11.15-ны өдрийн байдлаар өөрийн компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд 98.6% буюу хэвийн эрсдэлгүй түвшинд үнэлэгдсэн болно.

ний зүгээс компанийн засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайланг Монголын хөрөнгийн бирж
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Компанийн 2023 оны эхний хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр буюу 2023 оны 09-р сарын 13-ны өдрөөр нийт 1056 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд дараах бүтэц, бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хүснэгт 2

№	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	Хувьцаа эзэмшигчдийн иргэншил	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Эзэмшиж буй хувьцааны	
				Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Байгууллага	Гадаад	3	4,983,603	6.3
2		Дотоод	22	732,348	0.97
3	Иргэн	Гадаад	24	2,185,947	2.8
4		Дотоод	1007	70,641,103	90
Нийт			1056	78,543,001	100

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хүснэгт 3

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Иргэн Д.Зоригт	42,530,145	54.15%
2	Иргэн Д.Оюунсүрэн	23,460,015	29.87%
3	"Импера монголиа холдинг" ХХК	4,915,165	6.26%
4	Бусад	7,637,676	9.72%
Нийт хувьцааны тоо		78,543,001	100%

КОМПАНИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ТАЛААР

Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг, эзэмшлийн хувь хэмжээний талаарх мэдээлэл

Компанийн нийт хувьцааны тоо : 78,543,001

Хүснэгт 4

№	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог нэр	Эрхэлж буй ажил,	Эзэмшиж буй хувьцааны	
			Тоо ширхэг	Эзэмшлийн хувь
1	Дашзэвэг овогтой Зоригт	Иргэн	42,530,145	54.15
2	Дугаржав овогтой Оюунсүрэн	“Улаанбаатар дахь Америк ерөнхий боловсролын сургууль” ХХК-ийн гүйцэтгэх захирал	23,460,015	29.87
Нийт			65,990,160	84.02

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Манай компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага байдаг. ТУЗ-ийн гишүүдийг компанийн 2021 оны 4-р сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас “Компанийн дүрэм”-ийн 7.23-р заалтын дагуу 5 жилийн хугацаатай улируулан сонгосон. Одоогоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**ДУГАРЖАВЫН
ОЮУНСҮРЭН**

*ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд
ТУЗ-ийн дарга*

*Инженер эдийн засагч
мэргэжилтэй*

*"Улаанбаатар дахь Америк
ерөнхий боловсролын сургууль"
ХХК-ны гүйцэтгэх захирал*

Хувьцааны эзэмшил 29.87%



**НАМСРАЙН
МӨНХЗУЛ**

*ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин
урамишууллын хорооны гишүүн*

Эдийн засагч мэргэжилтэй

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Хувьцааны эзэмшил 0%



**ДҮВЧИНДОРЖИЙН
АЛТАНЧИМЭГ**

*ТУЗ-ийн ердийн гишүүн, Цалин
урамишууллын хорооны гишүүн*

Нягтлан бодогч мэргэжилтэй

"Одод" ХХК-ийн нягтлан бодогч

Хувьцааны эзэмшил 1.5%



**ДАШЦЭРЭНГИЙН
ТУЯА**

*ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудитын хорооны дарга*

Эдийн засагч мэргэжилтэй

*"Төрийн банк" ХК-ийн хэлстийн
захирал*

Хувьцааны эзэмшил 0%



**НЯМЖАВЫН
БАТСАЙХАН**

*ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудитын хорооны гишүүн*

Эдийн засагч мэргэжилтэй

*"Монгол даатгал" ХХК-ийн
Чингэлтэй салбарын захирал*

Хувьцааны эзэмшил 0%



**БАЛЖИННЯМЫН
АЛТАНГЭРЭЛ**

*ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудитын хорооны гишүүн*

*Банкны эдийн засагч
мэргэжилтэй*

*"Ар гурван хэц" ХХК-ийн
гүйцэтгэх захирал*

Хувьцааны эзэмшил 0%



**БАТСҮХИЙН
ОЮУНЦЭЦЭГ**

*ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр
дэвшүүлэх хорооны дарга*

*Инженер эдийн засагч
мэргэжилтэй*

*"Гермес Центр" ХК-ийн
гүйцэтгэх захирал*

Хувьцааны эзэмшил 0.1%



**БУЯНЦОГИЙН
АМАРСАНАА**

*ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр
дэвшүүлэх хорооны гишүүн*

Эрх зүйч мэргэжилтэй

*"Төрийн банк" ХК-ийн хэлстийн
захирал*

Хувьцааны эзэмшил 0%



**ЦЭЕНСҮРЭНГИЙН
ТҮВШИНЖАРГАЛ**

*ТУЗ-ийн ердийн гишүүн, Нэр
дэвшүүлэх хорооны гишүүн*

Зураач мэргэжилтэй

Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Хувьцааны эзэмшил 0.06%

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН

Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, компанийн үйл ажиллагааг зөв зохистой төвшинд хүргэх, зорилго, зорилтоо биелүүлэхэд Гүйцэтгэх удирдлагын багт шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг. Компанийн ТУЗ нь дээрх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа танхимаар 4 удаа хуралдаж, нийт 26 асуудлыг хэлэлцэн 11 тогтоол шийдвэрийг гаргалаа.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд 3 удаа танхимаар хуралдаж, 3 тогтоол, Цалин урамшууллын хороо 2 удаа хуралдаж 1 тогтоол, 1 саналыг тус тус гаргаж ажиллалаа.

График 5



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ ҮНЭ ХАНШ

“Гермес Центр” ХК-ийн хувьцаа нь 2023 онд 151 өдрийн арилжаа хийгдэж нийт 1,347,237 ширхэг буюу 160,442,376.08 төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна. Арилжааны дүнг өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан.

Сүүлийн 5 жилийн хувьцааны арилжааны тоон үзүүлэлтийг графикаар харуулав.

График 6



Манай компани нь Монголын Хөрөнгийн Биржийн 2 дугаар ангилалд багтдаг бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн зах зээлийн үнэлгээ 10.7 тэрбум төгрөг болсон. Компанийн 2023 оны нэгж хувьцааны хаалтын ханш 136.03 төгрөг байсан бөгөөд, хувьцаа эзэмшигчдийн өмч 1.3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График 7



НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

"Гермес центр" ХК нь Монголын хөрөнгийн бирж дээрх хамгийн идэвхитэй ногдол ашиг тараадаг компаниудын нэгэн бөгөөд 2014 оноос эхлэн хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашигт нийцүүлэн жилд 2 удаа ногдол ашиг хуваарилж байна. Дараах хүснэгтээр компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн мэдээллийг харуулав.

Хүснэгт 5

Ногдол ашиг хуваарилсан огноо	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (сая төг)	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Ногдол ашиг олгосон хэлбэр		Ногдол ашиг тараалтын хувь	
				ҮЦТХТөвөөр зуучлуулан бэлэн бусаар	Компани дээрээс		
2021	Эхний хагас жил	6.30	494.8	1013	70.9	423.9	100%
	Сүүлийн хагас жил	6.36	499.5	1010	71.5	428.0	100%
Нийт		12.66	994.3				
2022	Эхний хагас жил	8.02	629.9	1024	90.2	539.7	100%
	Сүүлийн хагас жил	7.50	589.1	1051	84.4	504.7	100%
Нийт		15.52	1219				
2023	Эхний хагас жил	12.00	942.5	1056	135.0	807.5	100%
	Сүүлийн хагас жил	9.20	722.6				
Нийт		21.20	1665.1				

Сүүлийн 5 жилийн хугацаанд нэгж хувьцаанд тараасан ногдол ашиг, хувьцаа эзэмшигчдэд тараасан ногдол ашгийн талаарх мэдээллийг харуулав.

График 8





График 9



“Гермес Центр” ХК нь тухайн жилүүдэд хуваарилсан ногдол ашгийг компанийн төв байр болон Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 100% тарааж, ногдол ашиг тараалтын тайлан мэдээллийг холбогдох журмын дагуу Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хэвлэмэл байдлаар хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллаж байна.

КОМПАНИЙН 2024 ОНЫ НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

“Гермес Центр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, санхүүгийн тайланд жилд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр 2 удаа хуваарилна.

КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ӨӨС ГАРГАСАН ДҮГНЭЛТ

“Гермес Центр” ХКомпанийн 2023 оны татварын дараах цэвэр ашиг 1,698.3 сая төгрөг байгаа бөгөөд энэхүү ашгийг төлөвлөгөө 1,571.6 сая төгрөг байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч төлөвлөгөөг 126.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2023 онд нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 21 төгрөг 62 мөнгө байгаа бөгөөд ногдол ашгийн төлөвлөгөө 20 төг 01 мөнгө байсантай харьцуулахад 108%-ийн биелэлттэй гарч, төлөвлөгөөг 1 төг 61 мөнгөөр давуулан биелүүлж ажилласан байна.

Тиймээс гүйцэтгэх удирдлагын багийг 2023 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай сайн ажилласан хэмээн ТУЗ-өөс дүгнэсэн болно.

КОМПАНИЙН 2024 ОНЫ ЗОРИЛТ

Хүснэгт 8

№	Агуулга	Дүн
1	Нийт орлого	2,906.2 сая ₮
2	Нийт зардал	1,175.4 сая ₮
3	Нийт цэвэр ашиг	1,606.3 сая ₮
4	Нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг	20 төг 45 мөн
5	Ажиллагсдын орон тоо	16

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2023 ОНД ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД ОЛГОСОН ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТУХАЙ

Тус компани нь 2023 онд ТУЗ-ийн цалинд 21.1 сая төгрөгийн зардлыг гаргаж олгосон.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10-р сарын 13-ны өдрийн 12 тоот тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн сард 660.0 төгрөг байхаар тогтоосон байна.

Тиймээс “Гермес центр” ХК-ийн ТУЗ-ийн даргын цалинг 720.0, гишүүдийн цалинг 660.0 төгрөг байхаар шинэчлэн тогтоох

Хүснэгт 9

№	Албан тушаал	Орон тоо	Нэг удаагийн хурлын цалин	Жилд хуралдах хурлын тоо	Жилийн нийт цалингийн зардал
1	ТУЗ-ийн дарга	1	720,000.00	4	2,880,000.00
2	ТУЗ-ийн гишүүд	8	660,000.00	4	21,120,000.00
3	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	660,000.00	4	2,640,000.00
Нийт төсөв		10			26,640,000.00

Жич : ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн цалинг олгох бөгөөд жилд 4 удаа буюу улирал тутам хуралдахаар тогтсон. Хуралд ТУЗ-ийн гишүүн ямар нэгэн шалтгаанаар оролцоогүй тохиолдолд цалин олгогдохгүй.

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

ТУЗ-ийн 2024 оны 02-р сарын 14-ний
өдрийн №5 тоот тогтоолын хавсралт №

"ГЕРМЕС ЦЕНТР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС (Хэлэлцэх асуудал)

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог :

Хувьцаа эзэмшигчийн нэр :

Регистрийн дугаар:

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Брокерийн компанийн нэр :

"Гермес Центр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 05-ны
өдрийн 15:00 цагт "Гермес Центр" ХК-ийн төв байранд болно.

Санал авах хуудас ашиглах санамж

Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ

1 хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан эсвэл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.

2 Засварласан, балласан болон залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

3 Хувьцаа эзэмшигч та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харилцдаг брокер дилерийн компани болон "Гермес Центр" ХК-ийн оффисын 3-р давхрын 302 тоот өрөөнд 2024 оны 4-р сарын 04-ний өдрийн 18:00 цагаас өмнө ирүүлнэ үү.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Компанийн ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай			

Хувьцаа эзэмшигч (Итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн гарын үсэг:()

Санал авах хуудас үйлдсэн 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга:(О.Золжаргал)

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

**“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт болон Компанийн дүрэм, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй(.....) хувийн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул тооллогын дүнг хавсралтын дагуу баталж, ээлжит хурлын даргад танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

О.ЗОЛЖАРГАЛ

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

Г.МАНДАЛЦЭЦЭГ

Б.ЧИМЭГЭЭ

**“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Тооллогын
дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, Компанийн дүрэм, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй хувийн хувьцаа эзэмшигчид (хавсралт №1) хүрэлцэн ирсэн тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсугай.
2. Хурлын ирц хангалттай тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН

**“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлангийн талаар
ТУЗ-өөс гаргасан дүгнэлт батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Гермес Центр” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн өгсөн дүгнэлтийг хавсралтын дагуу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн %-ийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН

**“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04-р сарын 05-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь :

1. “Гермес центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчийн %-ийн саналаар хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Д.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын 3 тоот тогтоолын хавсралт

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Албан тушаал	Орон тоо	Нэг удаагийн хурлын цалин	Жилд хуралдах хурлын тоо	Жилийн нийт цалингийн зардал
1	ТУЗ-ийн дарга	1	720,000.00	4	2,880,000.00
2	ТУЗ-ийн гишүүд	8	660,000.00	4	21,120,000.00
3	ТУЗ-н нарийн бичгийн дарга	1	660,000.00	4	2,640,000.00
Нийт төсөв		10			26,640,000.00

Жич : ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн цалинг олгох бөгөөд жилд 4 удаа буюу улирал тутам хуралдахаар тогтсон. Хуралд ТУЗ-ийн гишүүн ямар нэгэн шалтгаанаар оролцоогүй тохиолдолд цалин олгогдохгүй.

